



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 31

Шарга

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
хуралдаан зарлах, хэлэлцэх асуудал  
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит X хуралдааныг 2015 оны 10 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цагт Соёлын төвд хуралдуулсугай.

2. Тус хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1. 2015 оны төсвийн гүйцэтгэл, Орон нутгийн орлогын хагас жилийн тайлан хэлэлцэх тухай.

2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн хагас жилийн ажлын тайлан хэлэлцэх тухай.

3. 2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай.

4. Ойн мэргэжлийн байгууллага, Нөхөрлөлүүдтэй хийсэн гэрээний биелэлт, үр дүн.

5. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зээлийн олголт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх тухай.

6. Гурван буман малын баяр наадмын төсвийн тайлан. Баяр наадмын төсвийг бүрдүүлэх, зарцуулах бай мөрийг олгоход дагаж мөрдөх журмыг хэлэлцэх.

D:/Togtool 2015/

09 00

7. Сум дундын эмнэлэгийн 80 жилийн ойн арга хэмжээний төсвийн тайлан хэлэлцэх тухай./Сум дундын эмнэлэгийн ерөнхий эмч, ня-бо/

8. 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын саналуудыг урьдчилан эрэмбэлэн хэлэлцэх.

3. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

4. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны зар хүргэх ажлыг зохион байгуулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа /, Тамгын газрын даргыг түр өрлон гүйцэтгэгч /Т.Мөнхбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.АЗБАЯР

D:/Togtool 2015/

09 01

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 01 -ны  
37 дугаар тогтоолын Хавсралт



ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ Х ХУРАЛДААНЫ  
БЭЛТГЭЛ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн, Илтгэгч	Хяналт тавих эзэн
1	Хуралдааны зар хүргэх, хуралдааны танхим бэлтгэх	2015.10.01-2015.10.23	ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхбаяр, ИТХ-ын нарийн бичгийн дарга Л.Сэрсмаа	ИТХ-ын дарга
2	2015 оны төсвийн гүйцэтгэл, Орон нутгийн орлогын хагас жилийн тайлан хэлэлцэх тухай	2015.10.01-2015.10.23	Санхүүгийн албаны тасаг / Илтгэгч: Засаг дарга/	Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан хорооны дарга Д.Мягмар
3	Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн хагас жилийн ажлын тайлан хэлэлцэх тухай	2015.10.01-2015.10.23	Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг /Илтгэгч: Засаг дарга/	Байгаль орчин, Газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хорооны дарга Ж.Бумцэнд
4	2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай	2015.10.01-2015.10.23	Газрын даамал А.Энхбаатар /Илтгэгч: Засаг дарга/	Байгаль орчин, Газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хорооны дарга Ж.Бумцэнд
5	Ойн мэргэжлийн байгууллага, Нөхөрлөлүүдтэй хийсэн гэрээний биелэлт, үр дүн	2015.10.01-2015.10.23	Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг /Илтгэгч:Засаг дарга /	Байгаль орчин, Газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хорооны дарга Ж.Бумцэнд

6	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зээлийн олголт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх тухай	2015.10.01-2015.10.23	ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Б.Цолмонбаяр, /Илтгэгч: Ажлын хэсгийн Ахлагч/	Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, төсөл хариуцсан хорооны дарга М.Мөнхбаатар
7	Гурван буман малын баяр наадмын төсвийн тайлан, Баяр наадмын төсвийг бүрдүүлэх, зарцуулах бай мөрийг олгоход дагаж мөрдөх журмыг хэлэлцэх	2015.10.01-2015.10.23	Баяр наадмын комисс, Санхүүгийн албаны тасаг Баяр наадмын журам боловсруулах ажлын хэсэг/Илтгэгч: ИТХ-ын дарга/	Ёс зүй хяналт шалгалтын хорооны дарга Л.Баттулга
8	Сум дундын эмнэлэгийн 80 жилийн ойн арга хэмжээний төсвийн тайлан хэлэлцэх	2015.10.01-2015.10.23	Сум дундын эмнэлэгийн ерөнхий эмч Ц.Булгаа, нябо Ч.Оюунчимэг /Илтгэгч Ерөнхий эмч/	Эрүүл мэнд соёл боловсрол хариуцсан хорооны дарга Ча.Өнөржаргал
9	2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын саналуудыг урьдчилан эрэмбэлж хэлэлцэх	2015.10.01-2015.10.23	ЗДТГ, Ажлын хэсэг /Илтгэгч:Ажлын хэсгийн ахлагч/	Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан хорооны дарга Д.Мягмар